



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/265

Улаанбаатар хот

Сургалтын төрийн сангийн
санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2013 оны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 19 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны “Журам батлах тухай” 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2007 оны “Журам батлах тухай” 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцуулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хавсралтад дурдсан нэр бүхий иргэдийг 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадын их, дээд сургуулиудад суралцуулсугай.
2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
2015 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн
тоот тушаалын хавсралт

Сургалтын Төрийн сангийн зээлийн санхүүжилтээр
гадаадын их, дээд сургуульд суралцах оюутнууд

№	Овог	Нэр	Сургууль	Мэргэжлийн чиглэл	Хугацаа
1	Ганбаатар	Ганбаяр	Галлаудетийн их сургууль, АНУ	Дохионы хэлний багш, судлаач, бакалавр	4 жил
2	Цамбасүрэн	Мөнхтуяа	Америкийн Үндэсний их сургууль, АНУ	Төслийн удирдлага, магистр	2 жил
3	Мөнхжаргал	Чимэддорж	Харвардын их сургууль, АНУ	Төрийн захиргааны удирдлага, магистр	1.5 жил
4	Гансүх	Мөнхзул	Сидней их сургууль, Австрали	Хөдөө аж ахуй, хүрээлэн буй орчин, магистр	1.5 жил
5	Тогтохбаяр	Батбаяр	Өмнөд Дакотагийн уул уурхай, технологийн их сургууль, АНУ	Уул уурхайн инженер, менежмент, магистр	2 жил
6	Норжин	Дуламжав	Нагоягийн их сургууль, Япон	Боловсролын удирдлага, доктор	3 жил
7	Батцэнгэл	Болор-Эрдэнэ	Оксфордын их сургууль, Англи	Төрийн удирдлага, магистр	2 жил
8	Бат-Эрдэнэ	Батбаяр	Федерейшн их сургууль, Австрали	Мэдээллийн технологи, магистр	2 жил
9	Бархүү	Отгонбат	Харвардын их сургууль, АНУ	Төрийн захиргааны удирдлага, магистр	2 жил
10	Пүрэвдорж	Баяр	Миссури Мужийн их сургууль, АНУ	Сэргээгдэх эрчим хүчний менежмент, магистр	2 жил
11	Байгалмаа	Анхбаяр	Жорж Маршалын академи, Герман	Эрх зүйч-нийгмийн аюулгүй байдал, магистр	2 жил
12	Цэдэндамба	Отгонбаяр	Австралийн үндэсний их сургууль, Австрали	Төслийн удирдлага, магистр	2 жил
13	Баатар	Энхманлай	Дэври их сургууль, АНУ	Мэдээллийн системийн менежмент, магистр	2 жил
14	Баатар	Маралгоо	Калифорнийн менежмент шинжлэх ухааны их сургууль, АНУ	Төслийн удирдлага, магистр	1 жил